

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ТАНХИМД

Хяналтын журмаар гомдол гаргах нь:

Хяналтын журмаар гомдол гаргагч- Нэхэмжлэгч: УБ, СБД, 1-р хороо элчингийн гудамж, 14 210 “Жуулчин” ХХК

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Т.Солонго, Б.Баттзаяа

Нэхэмжлэгчийн утас: 9901521, 94000099

Хариуцагч: Нийслэлийн татварын газрын улсын байцаагч

Хариуцагчийн оршин суугаа газрын хаяг: Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Нэгдсэн үндэстний гудамж, 5/1

Хариуцагчийн утас: У.Оюунбилэг-89040707

Гомдлын үндэслэл:

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар *шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, хуулийг Дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн, эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой* гэж нэхэмжлэгч үзэж Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хяналтын журмаар уг гомдлыг гаргаж байна.

2024 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн 221/МА2024/0272 дугаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 136 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэгч “Жуулчин” ХХК-ийн Нийслэлийн татварын газрын татварын хяналт шалгалтын хэлтсийн татварын улсын байцаагч нарт холбогдуулан гаргасан “Нийслэлийн татварын газрын татварын хяналт шалгалтын улсын байцаагч У.Оюунбилэг, С.Тамираа нарын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн “Татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай” НА-22230000013 дугаар нөхөн ногдуулалтын актын 121,771,955 /нэг зуун хорин нэгэн сая долоон зуун далан нэгэн мянга есөн зуун тавин таван/ төгрөгт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах” шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

2024 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн 221/МА2024/0272 дугаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд хариуцагч талын хууль, олон улсын гэрээнд үндэслээгүй, албан бус эх сурвалжаас авсан тайлбар¹, эрх зүйн баримт бичгээр баталгаажаагүй албан бичиг² болон **НЭГ УЛСЫН ЗАХИРГААНД БАЙХ БҮС НУТГИЙГ БИЕ ДААСАН УЛС МЭТЭЭР ДҮГНЭЖ** шийдвэрлэсэн нь Шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ Монгол Улсын үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор

¹Хариуцагчийн Итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Мөнгөтулга

² Татварын Ерөнхий газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 04/1307 тоот албан тоот

нийтлэгдсэн хууль, Монгол улсын олон улсын гэрээг хэрэглэнэ болон Шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх зарчмыг алдагдуулсан гэж үзэхээр байна.

Давах шатны шүүхийн магадлалд³ Татварыг давхардуулж оногдуулахгүй байх, Татвар төлөхөөс зайлсхийх явдлаас уртдчилан сэргийлэх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 1 дүгээр зүйл “Энэхүү хэлэлцээр нь хэлэлцэн тохирогч хоёр улс буюу эдгээрийн аль нэгний нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээдийг хамаарна”, 2 дугаар зүйл “Хэлэлцэн тохирогч аль нэг Улс, түүний нутгийн эрх барих байгууллагуудаас орлогод оногдуулж буй татварууд нь тэдгээрийг хэрхэн оногдуулж байгаа хэлбэрээс үл шалтгаалан энэхүү хэлэлцээрт хамаарна”, 3 дугаар зүйлийн 1б “Хятад” гэж БНХАУ, газар зүйн утгаараа БНХАУ-ын бүх газар нутаг дэвсгэрийг хэлэх бөгөөд мөн Хятадын татварын хууль үйлчлэх БНХАУ-ын нутаг дэвсгэрт багтах тэнгис, түүнчлэн олон улсын хуулийн дагуу нөөцийг нь БНХАУ олборлох, ашиглах эрх бүхий далайн ёроол, түүний хэвлий БНХАУ-ын нутаг дэвсгэрт багтах тэнгисээс гадна орших нутгийг хэлнэ”, 3 дугаар зүйлийн 1в “Хэлэлцэн тохирогч Улс, Хэлэлцэн тохирогч нөгөө Улс гэж Хэлэлцээрийн заалтын утгаас хамааран Монгол болон Хятадыг хэлнэ” болон 3 дугаар зүйлийн 1з “Харьяа гэж хэлэлцэн тохирогч Улсын харьяат бүх хувь этгээд болон Хэлэлцэн тохирогч Улсын хуулийн дагуу зөвшөөрөгдөн ажиллаж буй хуулийн бүх этгээд, татвар оногдуулах утгаараа түүнтэй адилтгах хуулийн бус этгээдийг хэлнэ” гэх заалтуудыг зөв ишилсэн байх боловч тус заалтыг тайлбарлан хэрэглэхдээ болон хэрэгт авагдсан Татварын ерөнхий газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн “...Татварыг давхардуулж оногдуулахгүй байх, Татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Удсын Засгийн газар хоорондын хэлэлцээр нь эрх зүйн системийн хувьд БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс болох Хонконг хамаардаггүй. Хонконгтой давхар татварын гэрээ байгуулсан улсын жагсаалтыг Хонконгийн татварын албаны цахим хуудаснаас танилцах боломжтой” гэх **04/1307 дугаар албан бичиг**,

Хариуцагч талын “...Хонконг нь бие даасан статустай, бие даасан эдийн засагтай, бие дааж шийдвэр гаргадаг талаар заасан, Хонконг нь дэлхийн бусад улсуудтай бие дааж, тусдаа давхар татварын гэрээ байгуулдаг тул Засгийн газрын хоорондын хэлэлцээрийг энэ маргаанд хэрэглэхгүй” гэх тайлбар зэргийг үндэслэл болгон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконг Улс нь хэлэлцэн тохирогч хоёр улсад хамаарахгүй, эдийн засаг, засаг захиргааны бүтцийн хувьд бие даасан учраас уг хэлэлцээрийн зохицуулалтууд үйлчлэхээргүй байх тул Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 136 дугаар шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэгчийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон хууль зүйн үндэслэлгүй шийдвэрлэсэн.

Татварыг давхардуулж оногдуулахгүй байх, Татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр нь МУ-ын Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5. дах хэсэгт заасны дагуу заавал МУ-н УИХ-аар соёрхон батлах олон улсын гэрээ юм.

³ 2024 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн 221/МА2024/0272 дугаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал

Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 128/ШШ2024/0136 дугаар шүүхийн шийдвэрт дурдахдаа:

Монгол улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан байна.

Татварын Ерөнхий Хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнд татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” заасан.

Дээрх эрх зүйн зохицуулалтуудаас үзэхэд, Олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэхээр, Монгол улсын олон улсын гэрээнд татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөхөөр хуульчилсан байх тул Татварыг давхардуулж оногдуулахгүй байх, Татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай засгийн газар хоорондын хэлэлцээрийг тус маргаанд баримтлах нь зүйтэй гэж шүүх үзлээ.

Иймд дээрх Засгийн газар хоорондын хэлэлцээрийн холбогдох зохицуулалтуудад “Хятад” гэж БНХАУ, газар зүйн утгаараа БНХАУ-ын бүх нутаг дэвсгэрт хамаарахаар, оногдуулж буй татвар нь шан харамж, эрхийн шимтгэлийн нийт хэмжээний 10 хувиас хэтрэхгүй” гэж тус тус заасан ба Хонгконг нь БНХАУ-ын нутаг дэвсгэрт хамаарах нь тодорхой тул Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 10 хувиар тооцож татвар төлөх ёстой гэж нэхэжлэгч маргаж байгаа нь хууль зүйн үндэслэлтэй байна гэж шүүх дүгнэлээ гэж хууль зүйн үндэслэл бүхий, эх сурвалжтай зөв дүгнэлтийг хийсэн.

“Нийслэлийн татварын газрын татварын хяналт шалгалтын улсын байцаагч У.Оюунбилэг, С.Тамираа нарын 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн “Татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай” НА-22230000013 дугаар нөхөн ногдуулалтын актыг ногдуулахдаа маргаангүй, үндэслэл бүхий гаргасан тохиолдолд Нэхэмжлэгч тал нь маргаангүй төлөх боломжтой байсан. Бид хэдий алдагдалтай ажиллаж байсан хэдий ч төлөх ёстой бүхий л татварыг цаг хугацаандаа төлсөөр ирсэн ба зөвхөн давхар татварын хэлэлцээрийн дагуу 10 хувь уу 20 хувь уу гэдэг дээр үндэслэл бүхий тайлбар, шийдвэрийг авахаар гомдол гаргасан. Гэтэл татварын улсын байцаагч нар нь Татварын ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн А/34 тоот тушаалаар баталсан Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журмын 4.4.13а⁴ -д заасны дагуу Олон улсын татварын байгууллагаас тодруулах боломжтой байсаар байтал огт шалгаагүй, харин танин мэдэхүйн сайт дээрх мэдээлэлийг шалгасан гэж шүүх хуралдааны явцад тайлбарласан нь татвар төлөгчийн эрхийг ноцтой зөрчиж буй үйлдэл юм.”

Энэ мэтээр Олон Улсын гэрээг хэрэглэхдээ оролцогч талууд нь эргэлзээтэй, зөрүүтэй нэг мөр ойлгохгүй байсаар байгаа нь нэхэмжлэл гаргагчийн зөрчигдсэн болон зөрчигдөж байж болзошгүй эрхээ хамгаалуулж чадахгүйд хүрээд байна.

⁴ 4.4.13.а.Монгол Улсаас бусад улстай байгуулсан "Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр" (цаашид "Давхар татварын гэрээ" гэх) –ийн хүрээнд талуудын татварын зорилгоор аль улсад байнга оршин суугч болохыг тодорхойлж, татвар ногдуулах орлогын төрөл, эцсийн ашиг хүртэгчийг тодорхойлох;

Тухайлбал Захиргааны хэргийн давах шатны шүүхийн 221/МА2024/0272 дугаар магадлалд дурдсан Олон улсын гэрээний зүйл заалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн байдаг. Үүнийг татвар төлөгчийн зүгээс хэрэглэхдээ 1 дүгээр зүйл “Энэхүү хэлэлцээр нь хэлэлцэн тохирогч хоёр улс буюу эдгээрийн аль нэгний нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээдийг хамаарна” гэсэн нь уг хэлэлцээрийг байгуулсан хоёр улс /Хятад болон Монгол-ын нутаг дэвсгэр гэж тодорхойлогдох газар нутагт байнгын байдлаар оршин сууж буй этгээдүүдэд энэхүү хэлэлцээр нь хамааралтай гэсэн агуулгаар ойлгогдох тул нэхэмжлэгч байгууллагын хувьд уг хэлэлцээрийг ажил гүйлгээндээ хэрэглэх нэгэн үндэслэл болсон.

Мөн түүнчлэн 3 дугаар зүйлийн 16 “Хятад” гэж БНХАУ, газар зүйн утгаараа БНХАУ-ын бүх газар нутаг дэвсгэрийг хэлэх бөгөөд мөн Хятадын татварын хууль үйлчлэх БНХАУ-ын нутаг дэвсгэрт багтах тэнгис, түүнчлэн олон улсын хуулийн дагуу нөөцийг нь БНХАУ олборлох, ашиглах эрх бүхий далайн ёроол, түүний хэвлий БНХАУ-ын нутаг дэвсгэрт багтах тэнгисээс гадна орших нутгийг хэлнэ” – Энэ заалт нь уг хэлэлцээрийг хэрэглэх гэж буй этгээдийн 1 дүгээр зүйлд заасан “**хэлэлцэн тохирогч хоёр улс буюу эдгээрийн аль нэгний нутаг дэвсгэрт**” гэх хэсгийг БНХАУ-ын хувьд хэрхэн авч үзэж тодорхойлохыг дэлгэрэнгүй заасан агуулгатай заалт гэж ойлгож байна. Энэхүү заалт нь нийт 4 хэсэг агуулгыг багтааж байх ба үүнд: “Хятад” гэж

- БНХАУ, газар зүйн утгаараа БНХАУ-ын бүх газар нутаг дэвсгэрийг;
- Хятадын татварын хууль үйлчлэх БНХАУ-ын нутаг дэвсгэрт багтах тэнгис;
- Олон улсын хуулийн дагуу нөөцийг нь БНХАУ олборлох, ашиглах эрх бүхий далайн ёроол, түүний хэвлий;
- БНХАУ-ын нутаг дэвсгэрт багтах тэнгисээс гадна орших нутгийг бүгдийг нь ойлгохоор байна.

1984 оны 12 дугаар сарын 19-нд БНХАУ, Их Британийн засгийн газар Хонконгийн асуудлаарх Хятад-Британийн хамтарсан тунхаглалд гарын үсэг зурсан байдаг ба тунхаглал ёсоор 1997 оны 7 дугаар сарын 1-нээс Хонконг нь БНХАУ-д шилжин ирсэн байна. Хятад улс Хонконгийг шилжүүлэн авахаас өмнө 1990 оны 4 дүгээр сарын 4-нд БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал-аас Хонконгийн засаг захиргааны онцгой бүсийн үндсэн хуулийг баталсан байдаг⁵.

Тус Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд “Хонконгийн засаг захиргааны онцгой бүс нь БНХАУ-ын салшгүй нэг хэсэг юм” хэмээн заасан байх тул Хонконг нь газар зүйн утгаараа БНХАУ-ын бүх газар нутаг дэвсгэрт багтах учир хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 16 хэсэгт хамаарах үндэслэлтэй байна. Гэтэл Давах шатны шүүхээс дүгнэхдээ ... 04/1307 дугаар албан бичиг зэргээс үзэхэд **Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонконг Улс нь хэлэлцэн тохирогч хоёр улсад хамаарахгүй, эдийн засаг, засаг захиргааны бүтцийн хувьд бие даасан учраас уг хэлэлцээрийн зохицуулалтууд үйлчлэхээргүй байх тул гэдэг буруу дүгнэлтийг хийсэн.**

Хятад-Их Британийн хамтарсан тунхаглалд бусад зүйлсээс гадна, Хонконгийн тухай БНХАУ-ын үндсэн бодлогын тухай тусгасан байдаг. “Нэг улс, хоёр бодлого” зарчмын дагуу Хонконгийн засаг захиргааны онцгой бүсэд социалист тогтолцоо, бодлогыг хэрэгжүүлэхгүй байх, Хонконгийн өмнөх капиталист тогтолцоо, амьдралын хэв маяг 50 жилийн турш

⁵ <https://www.basiclaw.gov.hk/en/basiclaw/chapter1.html>

өөрчлөгдөхгүй хэвээр байна. Мөн эдгээр үндсэн бодлогыг Хонконгийн засаг захиргааны онцгой бүсийн үндсэн хуульд тусгана хэмээн хамтарсан тунхаглалд тусгасан байна.

Нэг улс, хоёр бодлого гэдэг нь БНХАУ нь гадагшаага буюу олон улс руу нэг улс байх бодлого баримтлах тул бид энэ давхар татварын хэлэлцээр Хонг Конг хамаарна гэж дүгнэж байна.

Нэхэмжлэгч тал нь давах шатны шүүх хуралдаанд дараах тайлбаруудыг гаргаж байсан боловч Давах шатны шүүх түүнийг харгалзан үзээгүй. Үүнд:

- 3 дугаар зүйлийн 1в “Хэлэлцэн тохирогч Улс, Хэлэлцэн тохирогч нөгөө Улс гэж Хэлэлцээрийн заалтын утгаас хамааран Монгол болон Хятадыг хэлнэ” гэж Хэлэлцээрийн заалтуудад тухайлан Хятад болон Монгол улс гэж заахгүйгээр орлогыг аль тал олж байгаа, төлбөрийг аль тал төлж байгаагаас шалтгаалан хэлэлцэн тохирогч улс, хэлэлцэн тохирогч нөгөө улсыг ойлгохоор байна.
- 3 дугаар зүйлийн 1з “Харьяа гэж хэлэлцэн тохирогч Улсын харьяат бүх хувь этгээд болон Хэлэлцэн тохирогч Улсын хуулийн дагуу зөвшөөрөгдөн ажиллаж буй хуулийн бүх этгээд, татвар оногдуулах утгаараа түүнтэй адилтгах хуулийн бус этгээдийг хэлнэ”- Уг хэлэлцээрийн аль нэг талын Улсын харьяанд буй тухайн улс орны хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж буй бүх этгээд, татвар оногдуулах заалттай хуулийн бус этгээд хүртэл хэлэлцээрийн дагуу харьяа болох тодорхой байна.
- 4 дүгээр зүйлийн 1. “Энэхүү хэлэлцээрт Хэлэлцэн тохирогч аль нэг Улсад байнга оршин суугч гэж гэж өөрөө болон удирдах, толгойлох байгууллага нь байнга оршин сууж, байрлаж байгаа, мөн түүнтэй адилтгах бусад шалтгаанаар оршин сууж, байрлаж тэр Улсын хуулийн дагуу тухайн Улсад татвар төлөх үүрэгтэй аливаа этгээдийг хэлнэ”.- Хэргийн материал авагдсан “Олон улсын Франчайз гэрээ”-ний 1 дүгээр зүйлд “Little Sheep” брэндийн оюуны өмчийн эрхийн хууль ёсны жинхэнэ эзэмшигч нь БНХАУ-н Өвөр Монголын Өөртөө Засах орны Inner Mongolia Little Sheep Catering Chain компани бөгөөд олон улсын зах зээлд уг брэндийг үйл ажиллагааг эрхлэх, ашиглуулах эрхийг өөрийн салбар компани болох Хонконгд зохион байгуулагдсан Little Sheep Hong Kong Holdings Company-д олгосон байдаг нь нотлогддог. Оюуны өмч нь хууль ёсны дагуу БНХАУ-д бүртгэлтэй, оюуны өмчийн жинхэнэ эзэмшигч, толгойлох байгууллага нь мөн адил БНХАУ-ын хуулийн этгээд байх тул уг хэлэлцээрийг хэрэглэх бүрэн үндэслэлтэй гэдгийг давхар нотлож байгаа болно.
- Татварын ерөнхий газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн “...Татварыг давхардуулж оногдуулахгүй байх, Татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Удсын Засгийн газар хоорондын хэлэлцээр нь эрх зүйн системийн хувьд БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс болох Хонконг хамаардаггүй. Хонконгтой давхар татварын гэрээ байгуулсан улсын жагсаалтыг Хонконгийн татварын албаны цахим хуудаснаас танилцах боломжтой” гэх 04/1307 дугаар албан бичиг – Энэхүү албан бичиг нь Монгол Улсын ОУ-н гэрээ буюу оролцогч талуудын маргаж буй хэлэлцээрийг хэрэглэх талаар шууд тайлбарласан байх ба Олон Улсын

гэрээний тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу Татварын асуудал эрхэлсэн төр захиргааны төв байгууллагад олон улсын гэрээг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар, зөвлөмж өгөх эрх хуулиар олгогдоогүй байтал ТЕГ-ын дээрх албан бичгийг Захиргааны хэргийн Давж Заалдах шатны шүүх магадлалдаа үндэслэл болгосон нь хуульд нийцээгүй гэж үзэж байна.

- Монгол Улсын Олон улсын гэрээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2. “Монгол Улсын дээд шүүх шаардлагатай бол олон улсын гэрээг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргана”, мөн зүйлийн 33.3. “Гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон улсын гэрээг зөв хэрэглэх талаар зөвлөмж өгч болно” гэх заалтуудыг Захиргааны хэргийн Давж Заалдах шатны шүүх анхаарч үзээгүй.

Иймд дээрх бүхий л үндэслэлийг харгалзан үзэж Захиргааны хэргийн давах шатны шүүхийн 221/МА2024/0272 дугаар магадлал Магадлалыг хүчингүй болгож, Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 128/ШШ2024/0136 дугаар шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэхийг хүсье.

Хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд хариуцагчийн төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулах нөхцөлөөр хангаж өгөхийг хүсье. /утас: 99901521/

“ЖУУЛЧИН” ХХК-Н
ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

Т.СОЛОНГО
Б.БАТЗАЯА

НИЙСЛЭЛ ДЭХ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ
№ 128
Хүлээн авсан
20 24 06 11 15 22
..... хавтас /..... хуудас / хэрэг / баримт бичиг /
Шилжүүлсэн
20 06 11
..... оны сарын